



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 29 өдөр

Дугаар А/94

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 14 дүгээр хуралдааны 14/01 дүгээр төсөв батлах тухай тогтоолын 2 дугаар хавсралтын 3.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шинэ Ховд баруун бүсийн хөгжлийн корпораци ОНӨААТҮГ-ын “Шинэ Ховд үйлдвэрлэл, технологи, инноваци нэвтрүүлэлт” үйл ажиллагааны зардалд 200,000,000 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 200,000,000 (Хоёр зуун сая) төгрөгийг аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 3.5 дахь заалтаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Гомбосүрэн) нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Батболд)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Э.БОЛОРМАА